



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2011 оны 01 сарын 31 өдөр

Дугаар 37

Улаанбаатар хот

“Увсбуян арвижих” хоршооны хадгаламж,
зээлийн үйл ажиллагаа эрхлэх
тусгай зөвшөөрлийг сунгах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, 6.2.5, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Увсбуян арвижих” хоршооны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2010 оны 11 дүгээр сарын 12-ны өдрөөс эхлэн 3 жилийн хугацаагаар сунгасугай.

2. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд сунгалтын талаарх тэмдэглэгээг 2011 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн дотор хийлгэхийг “Увсбуян арвижих” хоршоо /Ч.Гомбосүрэн/-нд үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бичил санхүүгийн газар /Н.Оюунчимэг/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН